# СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ

## ТОГТООЛ №2

2020 оны 02 сарын 14 Мандалговь хот

Тохирлын үнэлгээний тухай

Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13 зүйлийн 2 " Бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагад тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC 17065:2013 стандартын 7.6 заалт, орон нутгийн орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийн дүрмийн 1 зүйлийн 1.4.1 заалтыг тус тус үндэслэн баталгаажуулалтын байгууллагын орон тооны бус зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Дээрх заалтуудыг үндэслэн 2020 оны 02 сарын 14-ний орон тооны бус зөвлөлийн хурлын шийдвэрээр стандартын шаардлага хангасан аж ахуй нэгж, иргэнд тохирлын гэрчилгээ олгох эрхийг зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Бямба-Оюунд зөвшөөрч, /хавсралт-1/ баталсугай.
2. Баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлийн шийдвэрээр Номгон рашаан ХХК-ийн худалдааны газарт 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосугай.
3. Давтан баталгаажуулалт хийж, тохирлын үнэлгээний түвшинд хүрээгүй аж ахуй нэгж байгууллагад мэдэгдэл өгч холбогдох арга хэмжээ авч ажиллахыг орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Бямба-Оюун/ -д үүрэг болгосугай.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ж.ПҮРЭВСҮРЭН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БЯМБА-ОЮУН

Баталгаажуулалтын байгууллагын
орон тооны бус зөвлөлийн 2020 оны
02 сарын 14-ний өдрийн 2-р тогтоолын
1 дүгээр хавсралт

***Тохирлын гэрчилгээ шинээр олгосон, сунгуулсан ААН, иргэдийн нэрс***

| № | Сумын нэр | Аж ахуй нэгж | Үйлчилгээний нэр |
|---|---|---|---|
| 1 | Сайнцагаан | Номгон рашаан ХХК | Худалдаа |

Жагсаалт гаргасан: Б.Ямба-Оюун